МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

СЕСМИМ
Т Ө С Ө Л
МОНГОЛ УЛСЫН ОЛБОРЛОХ САЛБАРЫН
МЕНЕЖМЕНТИЙГ БЭХЖҮҮЛЭХ ТӨСӨЛ

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН БА УУЛ УУРХАЙ

Гансүхийн Оргилмаа

2018.03.13

Global Affairs Canada
Affaires mondiales Canada


AGRITEAM CANADA

Урьдчилсан шатны судалгааны зорилго,
хүрээ:

Энэхүү судалгаа нь зорилго нь: Монгол Улсын тогтоомж, эрх зүйн акт тэр дундаа үул уурхайн салбарын хууль тогтоомж, эрх зүйн актын хүрээнд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой ямар ямар эрх зүйн зохицуулалт байгааг тандах, үнэлэлт өгөх

Судалгааны хүрээ нь: Монгол Улсын хүчин төгөлдөр хууль тогтоомж, Хууль зүйн яаманд бүртгэлтэй эрх зүйн акт

Уур амьсгалын өөрчлөлтийн эрх зүйн тогтолцоо



№	Монгол Улсын олон улсын гэрээ	Гол амлалтууд
1	УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН СУУРЬ КОНВЕНЦ /1993-06-01/	(НҮБУӨСК) нь 1992 онд Рио-гийн дэлхийн дээд хэмжээний уулзалт дээр батлагдсан УАӨ-ийг шийдэх тодорхой арга механизмуудыг боловсруулах ерөнхий чиг, баримжааг тогтоож өгдөг үндсэн гэрээ юм. УАӨСК нь уур амьсгалын өөрчлөлтийн талаархи олон улсын бодлогыг тодорхойлоход хамгийн нөлөөтэй, өргөн хүрээтэй баримт бичиг билээ.
2	УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ТУХАЙ НҮБ-ЫН СУУРЬ КОНВЕНЦИЙН КИОТОГИЙН ПРОТОКОЛ /1999-07-08/	1997 онд Киотогийн протоколыг 2008-2012 онд хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах зорилгоор хөгжингүй орнуудын хувьд хууль ёсоор заавал биелүүлэх үүргийг байгуулж, байгуулсан. 2010 оны Канкун гэрээнүүд нь ирээдүйн дэлхийн дулааралт нь үйлдвэрлэлийн өмнөх түвшинтэй харьцуулахад 2.0 ° C (3.6 ° F) -ээр хязгаарлагдах ёстой гэж заасан. Доха Нэмэлтээр 2013-2020 оны хугацааг зааж, Протоколыг шинэчиллээ.
3	УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ТУХАЙ НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН СУУРЬ КОНВЕНЦИЙН ПАРИСЫН ХЭЛЭЛЦЭЭР /2016-09-01/	Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах болон уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох асуудалд хөгжингүй, хөгжиж байгаа ялгаагүй бүх улс орон дагаж биелүүлэх баримт бичиг • УАӨ-ийг бууруулах урт хугацааны зорилтыг тодорхойлсон • ХХЯ-ыг бууруулж дэлхийн дулаарлын хэмжээг 2°C-аас доош түвшинд хязгаарлах, цаашид 1.5°C-т барихын төлөө бүх улс орон чармайн ажиллах шаардлагатай гэж заасан

Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем болох www.legalinfo.mn цахим сайтаас ***уур амьсгалын өөрчлөлт, хүлэмжийн хий, ногоон хөгжил*** зэрэг түлхүүр үгээр хайлт хийж уур амьсгалын өөрчлөлттэй шууд хамааралтай дараах хууль тогтоомж байгааг тогтоолоо.

Хууль-12
УИХ-н тогтоол-3
Олон улсын гэрээ-4
Ерөнхийлөгчийн зарлиг-1
УИХ-аас томилогддог байгууллага, түүнтэй адилтгах албан тушаалтны шийдвэр-0
Үндсэн хуулийн цэцийн шийдвэр -0
Улсын дээд шүүхийн тогтоол-0
ЗГ-ын Тогтоол-7
Сайдын тушаал-0
Аймаг, нийслэлийн засаг даргын захирамж-0

Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний эрх зүйн орчин

Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой */хүлэмжийн хий, ногоон хөгжил гэснийг оруулаад оруулаад/* 20 гаруй хууль тогтоомж байгаа нь тухайн асуудлын хэр чухал асуудал вэ гэдгийг илтгэж байгаагаас гадна тодорхой зохицуулалтууд байгаа гэдгийг харуулж байна.

Голлох хууль тогтоомж

Хууль-12

- **Агаарын тухай**
- **Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай**
- **Засгийн газрын тусгай сангийн тухай**
- **Ойн тухай**
- **Улсын тэмдэгтийн хураамжийн тухай**
- **Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай**
- Бусад /Тухай оны төсвийн, гэрээ соёрхон баталсан гэх мэт/

УИХТ-3

- **Ногоон хөгжлийн бодлого батлах тухай №43**
- *Батлагдсан огноо: 2014-06-13*
- **Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр батлах тухай №2**
- *Батлагдсан огноо: 2011-01-06*
- **Төрөөс эрдэс баялгийн талаарх баримтлах бодлого №18**
- Батлагдсан огноо: 2014-01-16

ЗГТ-7

ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ (Уур амьсгалын) Дугаар 317

Батлагдсан огноо: 2011-11-09

Дагаж мөрдөх огноо: 2011-11-09

ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ /Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр/Дугаар 120

Батлагдсан огноо: 2000-07-19

Дагаж мөрдөх огноо: 2000-07-19

Агаарын тухай 2012 он

6.1.2.уур амьсгалын өөрчлөлтийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенц /цаашид “Конвенци” гэх/-ийг хэрэгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, экологийн эмзэг байдлыг болон уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулахтай холбогдсон арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангах үүрэг бүхий Уур амьсгалын үндэсний хороо байгуулах;

2017.1.25 оны 27 дугаар тогтоолын 20-р хавсралтаар Уур амьсгалын үндэсний хороог байгуулж, даргыг томилсон.

Хорооны ажиллах журмыг хэн батлах, чиг үүргээ хэрхэн хэрэгжүүлэх, хаанаас санхүүжих талаарх хуулийн зохицуулалт байхгүй.

Агаарын тухай 2012 он

6.1.Засгийн газар хүрээлэн байгаа агаар /цаашид “агаар” гэх/ хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1.агаар хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөрийг батлах, түүний хэрэгжилтийг зохион байгуулах;

Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр батлах тухай 2011-2021 -УИХ
Батлагдсан огноо: 2011-2001-06
Дагаж мөрдөх огноо: 2011-01-06

ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ /Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр /Дугаар 120-3Г
Батлагдсан огноо: 2000-07-19
Дагаж мөрдөх огноо: 2000-07-19

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 7.4-т заасан Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын төслийг Засгийн газар өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал батална гэсэнтэй зөрчилдөж байна. Мөн хуулийн 4.1.7-г хар.

Агаарын тухай 2012 он

24.2.Хүлэмжийн хийн ялгарал болон шингээлтийн улсын тооллогыг Конвенцийн талуудын бага хурлаар баталсан арга зүйн дагуу **ажлын алба** зохион байгуулж явуулна.

24.3. 24.3.Аж ахуйн үйл ажиллагааны явцад хүлэмжийн хийг ихээр ялгаруулах эх үүсвэрээс ялгарах хүлэмжийн хийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг төрийн захиргааны төв байгууллага холбогдох бусад байгууллагатай хамтран батална.

Хууль зүй дотоод хэргийн яаманд бүртгүүлсэн НДМЭЗА нэгдсэн бүртгэлийн жагсаалтад хүлэмжийн хийг ихээр ялгаруулах эх үүсвэрээс ялгарах хүлэмжийн хийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтоосон журам байхгүй.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай 2012 он

3.1.3.“байгаль орчны стратегийн үнэлгээ” гэж улсын болон бүс нутаг, салбарын хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах явцад түүний **хэрэгжилтээс байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэл, сөрөг нөлөөлөл, үр дагаврыг уур амьсгалын өөрчлөлтийн чиг хандлага,** гамшиг, аюулт үзэгдэл, осол, аюултай уялдуулан тодорхойлохыг;

Стратегийн үнэлгээг үндэсний бодлогын баримт бичигт (хөтөлбөрт) хийх ёстой байдаг. Засгийн газраас 2013 оны 11-р сарын 16-ны өдөр батлагдсан 370 дугаар журам нь уур амьсгалын өөрчлөлтийн болзошгүй эрсдэл, сөрөг нөлөөллийн чиг хандлагтай хэрхэн уялдуулах вэ гэдгийг энэ аргачлалд заагаагүй зэрэг дутагдал байгаа нь энэхүү журмыг шинэчлэн боловсруулах цаг болсныг илтгэж байна.

Тэмдэгтийн хураамжийн тухай 2010 он

21.1.10.озоны давхаргыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, байгаль орчинд ээлтэй бодис импортлох, худалдах, ашиглах зөвшөөрөл олгоход 11 000-27 000 төгрөг;

Энэ хуулийн 41 дүгээр зүйлд заасан Тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх, хөнгөлөхтэй холбоотой зохицуулалтад нэмж оруулах нь ач холбогдолтой байх талтай.

Засгийн газрын тусгай сангийн тухай 2010 он

- 6.4.2. Байгаль орчин, уур амьсгалын сан;
- 26.3.Энэ хуулийн 6.4-т заасан тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийг тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гаргах бөгөөд энэ хуулийн 6.4.4, 6.4.6, 6.4.10, 6.5.3-т зааснаас бусад тусгай санд зориулан ажлын алба байгуулж, санхүүжүүлэхийг хориглоно.

Ажлын алба байгуулахыг хориглосон зохицуулалт нь сангийн үйл ажиллагаа тасралтгүй үр дүнтэй явагдахад сөрөг нөлөөтэй байх талтай.

Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөрийн голлох зааltууд /2011-2021/

- УАӨ-ийг сааруулах, дасан зохицох үндэсний чадавхийг бэхжүүлж, эрх зүйн орчин, бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тогтолцоог бүрдүүлэн, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ;
- **Байгаль орчныг хамгаалах тухай, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай, Ойн тухай, Усны тухай, Эрчим хүчний тухай, Гамшгаас хамгаалах тухай, Газрын тухай, Барилгын тухай, Сэргээгдэх эрчим хүчний тухай зэрэг холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах;**
- Бэлчээр ашиглах, хөрс хамгаалах, эрчим хүч хэмнэх, үйлдвэрлэл, үйлчилгээний үр ашгийг дээшлүүлэх, ногоон хөгжлийг дэмжих, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг авах хариу арга хэмжээний тухай зэрэг харилцааг зохицуулсан эрх зүйн орчныг шинээр бүрдүүлэх; Хүлэмжийн хийн тооллого, тооцоонд шаардлагатай эх мэдээг улсын статистикийн мэдээлэлд бүрэн оруулах чиглэлээр эрх зүйн орчныг бий болгох;
- Эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээ, барилгын чанар, дулаалгын байдалд хөндлөнгийн аудит хийх механизмыг бий болгох;
- Эрчим хүч, уур, ус хэмнэлт, хог хаягдлын ашиглалт, боловсруулалтын шинэ норм, стандартыг боловсруулж мөрдүүлэх;
- УАӨ-ийн асуудал хариуцсан салбар дундын зохицуулалт хийх үүрэг бүхий бүтцийг бий болгох;
- Цэвэр хөгжлийн механизмийг хэрэгжүүлэх талаар эрх зүйн орчныг боловсронгуй болгох.

Хөтөлбөрийн дагуу хийгдэх ажил: *Байгаль орчныг хамгаалах тухай, Ус, цаг уур, орчны хяналт-шинжилгээний тухай, Ойн тухай, Усны тухай, Эрчим хүчний тухай, Ашигт малтмалын тухай, Газрын тосны тухай, Гамшгаас хамгаалах тухай, Газрын тухай, Барилгын тухай, Сэргээгдэх эрчим хүчний тухай зэрэг холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах*

Хугацаа: *2011-2016*

Хариуцах этгээд: *БОАЖЯ, ХЗДХЯ, ЭБЭХЯ, ЗТБХБЯ, ОБЕГ*

- Үр дүн: *Агаарын тухай, Ойн тухай, Усны тухай, Хөрс хамгаалах, цөлжилтөөс хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиудыг шинэчлэн найруулж уур амьсгалын өөрчлөлтийн талаарх зарим нэг зохицуулалт орсон боловч Гамшгаас хамгаалах тухай,* ***Ашигт малтмалын тухай, Газрын тосны тухай,*** *Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулиудад холбогдох нэмэлт өөрчлөлт ороогүй байна.*

Эрдэс баялгийн хууль тогтоомжид хэрхэн тусгагдсан эсэх?

Жишээ:

АМТХ
1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт ашигт малтмал эрэх, хайх, **ашиглах** болон **хайгуулын талбай, уурхайн эдэлбэрийн орчныг хамгаалахтай** холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Эрдэс баялгийн чиглэлийн хуулиудад үүр амьсгалын өөрчлөлт, түүнд дасан зохицох талаарх шууд заасан зохицуулалт байхгүй. Ашиглалтын явцад, ашиглалтын дараа хэрхэн үүр амьсгалын өөрчлөлтийн асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд авч үзэх вэ гэдэг нь хамгийн чухал асуудал болоод байна.

Хог хаягдлын тухай хууль 2017 он

8.6.Хог хаягдлын талаар үүл уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.6.1.үүл уурхайн олборлолт, боловсруулалтаас үүсэх хог хаягдалд хяналт тавих, үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

8.6.2.үүл уурхайн олборлолт, боловсруулалтаас үүсэх хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах журам баталж, хэрэгжилтэд хяналт тавих;

8.6.3.энэ хуулийн **8.1.3-т заасан** журмын дагуу үүл уурхайн олборлолт, боловсруулалтаас үүссэн хог хаягдлын тайланг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд ирүүлэх.

8.6.2-т заасан журам, 8.1.3-т заасан журам /Хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх/ тус тус батлагдаагүй.

МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ-2030

- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний чадавхийг бүрдүүлж, цаг агаарын аюулт үзэгдэл, байгалийн гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлнэ.
- Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи нэвтрүүлж, үйлдвэрлэл, хэрэглээнд нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулна.



Take urgent action to combat climate change and its impacts

Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого /2014.1.16/

Олборлох

- хөгжлийн чиг хандлагатай уялдуулсан орчин үеийн, ОУ-ын стандартад нийцсэн, ЭЗ-ийн өсөлтийг хангах, экспортын чиг хандлагатай, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, БОХ шаардлагыг хангасан, ил тод, хариуцлагатай уул уурхайн олборлох болон боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого баримтлах;
- стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод төрийн хяналт, зохицуулалт, хариуцлагыг дээшлүүлэх замаар үйл ажиллагаа, эдийн засгийн үр өгөөжийг сайжруулж, PPP-ийн ажиллагааг боловсронгуй болгох;
- хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай техник, технологийг ашиглаж ил тод, хариуцлагатай уул уурхайн зарчимд нийцсэн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийг дэмжих;

Боловсруулах

- зах зээл дэх өрсөлдөх чадвар, үйлдвэрлэлд зарцуулагдах усны хэрэглээ болон үйлдвэрлэлээс гарах хорт хаягдал, хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл зэрэг хүчин зүйлийг цогцоор нь судалж, шийдвэр гаргах;
- боловсруулах салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

Нөхөн сэргээх

- уурхайн нөхөн сэргээлт, хаалтын стандарт, журмыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулах;
- эрдэс баялгийн олборлох болон боловсруулах үйлдвэрлэлд газрын гүний цэнгэг усыг аль болох ашиглахгүй байх, гадаргын усыг түлхүү ашиглах, холбогдох хуульд заасны дагуу хэрэглэсэн усыг дахин ашиглах, уул уурхайн салбарын ахуйн хэрэглээнд саарал усыг ашиглах, орчин үеийн дэвшилтэт технологийг дэмжих;
- олборлох, боловсруулах үйлдвэрийн хаягдлыг дахин боловсруулахад хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай, үр ашигтай техник, технологи хэрэглэхийг дэмжих зэрэг арга хэмжээ авна

Ногоон хөгжлийн үзэл баримтлал /2014.6.13/

Энэхүү баримт бичигт ногоон хөгжил, ногоон эдийн засаг, өсөлт, үйлдвэрлэл, худалдан авалт, санхүүжилт зэргийг тодорхойлсон бөгөөд бүгд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад чиглэгдсэн. Байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай үйлдвэрлэл, хэрэглээг хөгжүүлэх, Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн орчны бохирдол, доройтлыг бууруулж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгах Ногоон эдийн засгийг дэмжих санхүүжилт, татвар, зээл, урамшууллын оновчтой хөшүүргийг нэвтрүүлж, байгаль хамгаалал, хүний хөгжил, цэвэр технологийг дэмжих хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зэрэг нь энэ бодлогын гол стратегийн зорилт билээ.

Ногоон хөгжлийн үзэл баримтлал /2014.6.13/

эрдэс баялгийн салбарт нөөцийг үр ашигтай, хаягдалгүй ашиглах технологи бүхий үйлдвэрлэлийг дэмжих;

уламжлалт болон уламжлалт бус газрын тосны эх үүсвэрийн хайгуул, олборлолтод олон улсын стандартыг нутагшуулж мөрдөх, байнгын хяналт-шинжилгээ хийх замаар орчны бохирдлоос сэргийлэх;

ил тод, хариуцлагатай олборлох үйлдвэрлэлийг төлөвшүүлж, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах ажлын үр дүнг дээшлүүлэн, уул уурхайн үйл ажиллагааны улмаас хүрээлэн байгаа орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх;

байгаль орчинд ээлтэй , хүний эрүүл мэнд болон биологийн олон янз байдалд сөрөг нөлөөгүй дэд бүтэц, тээврийн сүлжээг хөгжүүлэх Уул уурхай, дэд бүтэц гэх мэт салбарт байгальд ээлтэй гэхээс илүү байгаль орчинд сөрөг нөлөө багатай гэсэн ойлголтыг ашиглах

Хууль тогтоомжийн хийдэл 1

- Уур амьсгалын өөрчлөлтийн асуудал нь зарим хууль тогтоомжийн хүрээнд нэлээдгүй тусгагдсан боловч хангалттай тодорхой зохицуулалт байхгүй байна. Тухайлбал, уул уурхайн салбарын хувьд энэ асуудал дээр хэн ямар арга хэмжээг ямар журмаар ямар хугацаанд авч хэрэгжүүлэх, яаж хяналт тавих нь тодорхойгүй байна;

Үндэсний хөтөлбөр болон түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд уул уурхайн чиглэлийн уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг хариуцах салбарыг зөрчилдөөнтэй зааж өгсөн.



Хууль тогтоомжийн хийдэл 2

Уур амьсгалын өөрчлөлтөд уул уурхайгаас үзүүлэх нөлөөлөл, уур амьсгалын өөрчлөлтөөс уул уурхайд үзүүлэх нөлөөллийн эрсдлийн үнэлгээ хийх аргачлал байхгүй.

Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулахад дөхөм болохуйц техник технологи /сэргээгдэх эрчим хүч ашиглах, усны хэрэглээг бууруулах/ ашиглаж буй тохиолдолд урамшуулах механизм байхгүй.



Үйл ажиллагааны хийдэл


Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох талаар олборлох салбарын мэргэжилтнүүдийн мэдлэг, мэдээлэл, туршлага хангалттай биш;





Монгол Улсын хэмжээнд олборлох салбарын хүрээнд уур амьсгалын өөрчлөлттэй хэрхэн холбогдож байгаа талаар судалгаа тутмаг байна.

Төрийн байгууллагын бүтэц, чиг үүргийн хүрээнд анхаарах асуудал



Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар төрийн байгууллагын чиг үүргүүд нь /УИХ-аас хууль тогтоомж батлах, Засгийн газраас хэрэгжүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангуулах, Ерөнхийлөгчийн зүгээс үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудал гэдэг утгаараа чиглэл өгөх, яамдын хүрээнд бодлого боловсруулах, санал өгөх, мэргэжлийн хяналтын байгууллага хяналт тавих/ хүрээнд холбогдох хуулиараа зохицуулагдаж байгаа боловч хамгийн чухал бодлого боловсруулах, хэрэгжүүлэх чиг үүрэг нь Байгаль орчин, аялал жуучлалын яаманд байгаа бөгөөд дэргэдээ Байгаль орчин, уур амьсгалын тусгай сантай. Уур амьсгал, гадаад хамтын ажиллагааны хэлтэс ажиллаж байна.

Зөвлөмж

- Ашигт малтмалын тухай, Газрын тосны тухай зэрэг салбарын хуулиудад ногоон хөгжлийн сайн туршлага болон уур амьсгалын өөрчлөлттэй дасан зохицох эрх зүйн орчны бий болгохоор нэмэлт өөрчлөлтийг оруулах;
- Хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай техник, технологийг ашиглаж ил тод, хариуцлагатай уул уурхайн зарчимд нийцсэн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийг дэмжих эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож олон улсын стандартуудыг нэмэгдүүлэх;

- Уур амьсгалын өөрчлөлтөд уул уурхайгаас үзүүлэх нөлөөлөл, уур амьсгалын өөрчлөлтөөс уул уурхайд үзүүлэх нөлөөллийн эрсдлийн үнэлгээ хийх аргачлалыг нэвтрүүлэх;
- Салбарын хүрээнд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох судалгааг нарийвчлан хийх
- Салбарын яам агентлагийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах
- Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулахад дөхөм болохуйц техник технологи /сэргээгдэх эрчим хүч ашиглах, усны хэрэглээг бууруулах/ ашиглаж буй тохиолдолд урамшуулах механизмыг хууль тогтоомжийн хүрээнд бий болгох /татварын, тусгай зөвшөөрөл олгохдоо тусгайлан анхаарч үзэх/ ;

- Холбогдох хууль тогтоомжийг уялдуулах;
- Иргэд, хуулийн этгээдэд зөв мэдээлэл түгээх
- Одоогийн хүчин төгөлдөр хууль тогтоомжийн хийдлийг нөхөх зохицуулалт хийх

Жишээ: Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх хөтөлбөрийг уялдуулах

Тухайлбал: Уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлөх, нөлөөлөлд өртөх хүчин зүйлийг зөв тодорхойлох

АМТХ-ийн 27.1.13-т геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн ТЗБ-д байгаль орчин, нөхөн сэргээлт, уурхайн хаалтын асуудлаар тогтмол мэдээлэх үүрэг бүхий ажилтантай байх нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг болон орсон байдаг харин уул уурхай, хүнд яамны бүтцэд байгаль орчин нөхөн сэргээлтийн бүтэц, байхгүй, үүнд хэрхэн хяналт тавих тогтолцоо байхгүй байна. Ашигт малтмалын тухай хуулийн 10.1.14-т уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлахаар заасан одоо болтол батлагдаагүй хийдэл үүсгэж байгаа.

Баярлалаа